

ТУЗ ын хурал 2022 оны 02 сарын 18-ны  
өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

**“Тээвэр Дархан” ХК-ний 2021 оны  
Санхүүгийн ажлын тайлан**

Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулъя.

**Хөрөнгө**

2021 оны жилийн эцсийн тайлангийн үндсэн үзүүлэлт болох нийт хөрөнгийн дүн 3502,6 сая төгрөг байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө 357,5 сая төгрөг буюу 10,2%-ийг, эргэлтийн бус хөрөнгө 3145,1 сая төгрөг буюу 89,8 %-ийг эзэлж байна. Санхүүгийн эх үүсвэрт нийт өр төлбөр 722,4 сая төгрөг, эзэмшигчийн өмч хөрөнгө 2780,2 сая төгрөг байна. Үүнээс тухайн жилийн алдагдал 219,0 сая төгрөг байна. Тухайн үзүүлэлтүүдийг нийт хөрөнгийн дүнтэй харьцуулахад өр төлбөр 20,6 %, хуримтлагдсан ашиг 26,3% байна.

**Орлого**

2020 оны нийт борлуулалтын орлого 2674,2 сая төгрөг байсан ба 2021 оны нийт борлуулалтын орлого 2073,9 сая төгрөг байна. Үүнээс харахад 2021 оны борлуулалтын орлого өмнөх жилээс 600,3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй харагдаж байна. 2020-2021 онуудын борлуулалтын орлого буурсан нь манай оронд төдийгүй дэлхий даяаар тархсан ковид-19 болох хар тахалын улмаас нийт түрээслэгчдийн борлуулалтын орлого буурч санхүүгийн байдал хүндэрсэн нь мөн манай компанийн хувьд ч ялгаагүй түрээслэгчдийн тоо буурах хандлагатай байсан учраас компанийн зүгээс захирлын зөвлөлийн хурлаар шийдвэр гаргаж нийт түрээсийн төлбөрийг 2021 оны 1-р сараас 8 сар хүртэл 30%, 9 сараас 12-р сар хүртэл тус тус 15% хөнгөлсөн болно.

**Зарлага**

Тайлант жилд 2260,7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна. 2021 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлыг 2020 оныхтой харьцуулахад 547,5 сая төгрөгөөр буурсан нь засгийн газраас ашиглалтын зардлыг чөлөөлсөнтэй холбоотой харагдаж бна.

**Ашиг**

Тайлант жилд 357,5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж 2073,9 сая төгрөгийн орлоготой 2260,7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч 219,0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Дансны авлага**

2021 оны эцсийн үлдэгдэл болж буй 262,4 сая төгрөгийн авлага нь тодорхой хугацаатай, байгууллага хувь хүн болон ажилчдын хэрэгцээнд зориулагдсан түр зээл хэлбэрээр байна.

**Дансны өглөг**

2021 оны байдлаар банкны зээл 380,2 сая төгрөг, татвар НДШ-ийн өглөг 172,1 сая төгрөг ноогдол ашгийн өглөг 130,7 сая төгрөг бусад өглөг 39,4 сая төгрөг нийт 722,4 сая төгрөгний өр байна, Борлуулалтын орлого буурсантай холбоотой өр төлбөр нэмэгдсэн байна.

**Дүгнэлт:**

Санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн “ДАЯН СОФТ” программыг ашиглан ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн хөндлөнгийн хяналтыг “ПИЙК ОМ Аудит” ХХК-тай гэрээ байгуулан улирал бүрийн тайлан балансад дүгнэлт гаргуулан, зөвлөгөө авч ажилладаг бөгөөд өгсөн зөвлөмж дүгнэлтийг мөрдлөг болгон ажиллаж байна. “ПИЙК ОМ Аудит” ХХК мэргэжлийн зөвлөмжөөр сайн ханган ажиллаж байна.

Ерөнхий ня-бо



Д.Бямбажаргал